



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

“Талын салхи-2018” олон улсын мото наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 03/08 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.49, Нийслэлийн Засаг даргын А/506 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоод, гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, жуулчдын сонирхлыг татах зорилгоор “Талын салхи-2018” олон улсын мото наадмыг 06 дугаар сарын 09, 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын ивээл дор зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс / Ш.Ундармаа/-т үүрэг болгосугай.

2. “Талын салхи-2018” олон улсын мото наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Наадмыг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 13,325,000 /Арван гурван сая гурван зуун хорин таван мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Арга хэмжээний үеэр хамтран ажиллах, гэрээ байгуулах байгууллагуудыг судалж, 2018 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс өмнө танилцуулахыг Ажлын хэсэг /Б.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500153

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 31 өдрийн А/46 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284025 СБТ-8936 1118263562

**“ТАЛЫН САЛХИ-2018” ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

| | | |
|-------------------------|--------------|---|
| Ажлын хэсгийн дарга | В.Батчимэг | /Бодлого төлөвлөлтийн хэлстийн дарга/ |
| Гишүүд | А.Эрдэнэцогт | /Маркетинг, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн/ |
| | З.Оюуншүр | /Хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/ |
| | Г.Азжаргал | /Олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн/ |
| Нарийн бичгийн дарга | Ш.Ундармаа | /Соёлын аялал жуулчлал, салбарын хамтын ажиллагаа мэргэжилтэн/ |

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 31 өдрийн А/46 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 2016 1118263502

“ТАЛЫН САЛХИ-2018” ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Зардлын зүйл | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ |
|---|--|------------------|----------|------------|
| 1 | “Талын салхи” наадмын талаарх кино нэвтрүүлэг бэлтгэн, цацах | 45 минут | 135 000 | 6 075 000 |
| 2 | Арга хэмжээний үеэр хэрэглэх салют | 100 ш | 28 000 | 2 800 000 |
| 3 | Асрын түрээсийн үнэ /5:5 хэмжээтэй/ | 30 ш | 100 000 | 3 000 000 |
| 4 | Тэрэлж дэх арга хэмжээнд хэрэглэгдэх сандал, ширээний түрээс | 400 ш /санда/ | 2000 | 800 000 |
| | | 50 ш /ширээ/ | 5000 | 250 000 |
| 5 | Арга хэмжээний танилцуулга хэвлүүлэх | 1000 ш | 400 | 400 000 |
| | Нийт дүн | | | 13 325 000 |